



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/40

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх хэсэг, 32.1.3 дахь хэсэг, 32.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2026 оны 02 дугаар сарын 25, 2026 оны оны 03 дугаар сарын 02-ны өдрүүдэд орсон цас болон цасан шуурганы улмаас зам, даваа боогдож иргэд малчид зорчих хөдөлгөөн хийх нөхцөл боломжгүй болсон мөн 03 дугаар сарын 12-ны өдөр цас нэмж орох эрсдэлт нөхцөл байдал үүссэн тул учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж Зөөлөн, Өлзийт, багуудад цасанд боогдсон Дундат, Худагт, Хөндлөн, Чандмань, Салбар гэх газруудад зам даваа гүвээг чөлөөлж зорчих хөдөлгөөнийг нээх үйл ажиллагааны шатахууны зардалд 1 879 000 (нэг сая найман зуун далан есөн мянган) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг Гамшгийн эрсдэлийн сангийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ХАТАНБААТАР